

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

**Байгууллагын нэр: Монголбанк**

**Тодруулга өгөх албан тушаалтан: Ц.Мөнхжаргал (Хяналт шалгалтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн хянан шалгагч Утас: 310413, )**

**Б.Мөнх-Орших (Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн хэрэгжилт, хяналтын хэлтсийн мэргэжилтэн Утас: 328298, 99068033)**

**Тайлан нэгтгэсэн огноо: 2019.04.01**

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг		
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх.	
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсвөөс санхүүжихгүй.	
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Монголбанк	
5.	Хэрэгжих нийт хугацаа	6 жил	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b>Зээл авахад иргэн, аж ахуйн нэгжид учирч байгаа хүндрэл, зээлийн нөхцөлд дүн шинжилгээ хийж, зээлийн нөхцлийг хөнгөвчлөх арга хэмжээг авах.</p> <p><b>Зорилт 2.</b>Банк зээл олгоходоо авдаг шимтгэлийг бодитой тогтоох.</p> <p><b>Зорилт 3.</b> Банкны зээлийн бодлого, түүний журмыг боловсронгуй болгох, зээл авагч, зээлдүүлэгчийн тэгш байдлыг хангасан эрх зүйн орчинг бүрдүүлэх.</p> <p><b>Зорилт4.</b> Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах.</p> <p><b>Зорилт5.</b> Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах.</p>	
7.	Зардал	Төсөв	Төсвөөс санхүүжихгүй
		Үүнд:	Төсөв
		1-р үе шат	-
		2-р үе шат	-
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>			
8.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Гүйцэтгэлийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ бүрээр, хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хамт зохихталбартбичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:	<ul style="list-style-type: none"> <li>Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-193/228 дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан. Энэ журмаар банкны харилцагчийн зээлийн эцсийн ангиллыг илүү уян хатан</li> </ul>	

		<p>байдлаар тодорхойлох боломж бүрдсэн. Тухайлбал, хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэний хувьд 15 хүртэлх хоног, аж ахуйн нэгжийн хувьд 30 хүртэлх хоногт багтаан эргэн төлөх боломжтой гэж банк үзвэл уг зээлийг хэвийн ангилалд бүртгэж болохоор журамлаж өгсөн. Ингэснээр түр зуурын санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчийн зээлийн түүхийг хамгаалах боломжтой болсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тэтгэвэр барьцаалсан зээлийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хамтран ажиллах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, арилжааныбанк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан дараах ажил гүйцэтгэсэн. Үүнд:</li> <li>• Тэтгэвэр барьцаалсан зээлийн дээд хугацааг арилжааны бүх банкинд адил байхаар тогтоох, тэтгэврийн тодорхой хувьд зээл олгох асуудлыг шийдвэрлэж мөрдүүлэх;</li> <li>• Тэтгэвэр барьцаалсан зээл олгох зориулалтаар арилжааны банкинд байршуулсан нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрт заавал байлгах нөөцийг тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн.</li> <li>• “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэгт Монголбанкны мэргэжилтнүүдээс гадна Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” ТББ-ийн төлөөллүүд багтаж байна. Тус стратеги төлөвлөгөөг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2018 оны 10 дугаар сард баталсан бөгөөд эхний бичлэлийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гаргахаар төлөвлөн ажиллаж байна.</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” шинэчлэн батлагдсан. Энэ журмын “Харилцагчийн эрх ашгийг хамгаалах” тусгай бүлэг нэмэгдсэн, тухайлбал, иргэнд олгосон зээлийн хүүг олгох зээлийн дүнгээс урьдчилж төлүүлэхийг хориглосон (журмын 5.4 заалт)Мөн уг журмын хэрэгжилтийг банкууд дээрх хийгдсэн газар дээрх иж бүрэн шалгалтын хүрээнд хянаж байна.</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 8 дугаар сарын 01 –ний өдрийн А-209 тоот тушаалаар Иргэний зээлийн мэдээллийн лавлагаанд хамаарах мэдээллийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт баталсан.Уг нөхцөлд: - 2018 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө санхүүгийн түрээс (лизинг)-ийн төлбөр нь бүрэн төлөгдөж дууссан, - Нэг удаагийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй санхүүгийн түрээсийн төлбөрийн түүхтэй иргэний Монголбанкны Зээлийн мэдээллийн сан дахь сөрөг түүхийг хэвийн ангилалд шилжүүлсэн. Уг шийдвэрийн дагуу нийт 14170 иргэний мэдээлэл дээрх нөхцөлийг хангасан байна.</li> <li>• Нэг дүгээр зорилтын хүрээнд хийгдсэн ажил нь гурав дугаар зорилтын ажлуудтай давхцаж байгаа тул гурав дугаар зорилтын хүрээнд хийгдсэн ажлуудтай танилцана уу.</li> </ul>
	2-р зорилтын хүрээнд:	<ul style="list-style-type: none"> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” шинэчлэн батлагдсан. Энэ журмын дагуу банк зээл хүсэгч иргэн, хуулийн этгээдэд зээлийн бодит өртөгийн заавал танилцуулахаар болсон (журмын 1.3.7, 1.3.8, 2.6, 2.7, 2.8)</li> <li>• Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 хэсэгт “<i>Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно</i>” гэж зохицуулсан байдаг бөгөөд Монголбанкнаас зээлийн хүү, шимтгэлийг бодитой тогтоосон эсэхэд хяналт тавьж ажилладаг.Мөн Монголбанк иргэдээс банкуудын тогтоосон зээл, шимтгэлтэй холбоотой гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг.</li> <li>• Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 хэсэгт “<i>Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална</i>” гэж</li> </ul>

		<p>зохицуулсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-236 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлан мөрдүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>Банкны салбараас санхүүгийн үйлчилгээ авах иргэд, аж ахуйн нэгжид бодит мэдээллээр өгөх үүднээс банкуудын хадгаламж, зээлийн үйлчилгээний зарласан хүү, шимтгэл, бодит өртөгийн талаарх мэдээллийг сар бүр Монголбанкны цахим хуудсанд байршуулдаг. <a href="https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=6">https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=6</a></li> </ul>
3-р зорилтын хүрээнд:		<ul style="list-style-type: none"> <li>Монголбанк "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян"-ыг 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 5 сарын хугацаатай амжилттай хэрэгжүүлж дууссан. Тус аянд Монголбанкны нийт 17 хэлтэс, салбараас гадна Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын ипотекийн корпораци, Бичил санхүүгийн хөгжлийн сан болон Монголын банкны холбоонд гишүүнчлэлтэй нийт 14 банкттай хамтран орон даяар зохион байгуулсан ба давхардсан тоогоор нийт 1,5 сая хүнд хүрч ажилласан. Энэхүү аянаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн оновчтой шийдвэр гаргахад нь туслах, эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлж, оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах,</li> <li>Санхүүгийн тэнцвэргүй байдлаас сэргийлэх зохицуулагч этгээдүүдийг эрх, үүргийн тодорхой болгох, энэ чиглэлд хяналт шалгалт хийдэг тусгай бүтэц бүрдүүлэх,</li> <li>Шимтгэл, хураамж болон санхүүгийн үйлчилгээний нэмэлт төлбөрийн талаарх ойлголтыг нийгэмд хүргэх,</li> <li>Орон сууцны ипотекийн зээл хүсэгчдэд чиглэсэн зөв, тодорхой ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх,</li> <li>Зээлийн мэдээллийн сангийн ойлголт, мэдээлэл нийлүүлэгч талууд болон хэрэглэгч өөрийн мэдээллийг хэрхэн авч ашиглах, хяналт тавих талаар олон нийтэд хүргэх зэрэг арга хэмжээг авах,</li> <li>Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэсэн шинэ зохицуулалт орсон дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар "Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан ба тус ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас хамтран оролцож, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг судлан дуусаж хуулийн төслийг эхний байдлаар боловсруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас саналыг авч ажиллаж байна.</li> <li>Монголбанкнаас санаачлан боловсруулж буй "Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулах болон цаашид Монгол Улсад энэхүү тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай техникийн туслалцааг хүсэхээр Азийн хөгжлийн банкттай хамтран ажиллаж байна.</li> </ul> </li> </ul>
4-р зорилтын хүрээнд:		<ul style="list-style-type: none"> <li>Банкны тухай хуулийн 7 зүйлийн 7.4.1 дэх заалтад “дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох”-ыг хориглоно гэж заасан байна. Энэ заалтын дагуу Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна.</li> <li>2018 оны 1 дүгээр сард Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр арилжааны банкууд охин компанитай байхыг хязгаарлаж банкууд санхүүгийн болон санхүүгийн бус салбарт тэгш бус өрсөлдөөн бий болох эрсдэлийг буурууллаа.</li> <li>Банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн</li> </ul>

		<p>даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 140/400/А-168/38 дугаар хамтарсан тушаалаар баталлаа.Энэхүү стратеги нь бодлогын чиглэл болсон банкны системийн чанаргүй активын нөхцөл байдлыг тодорхойлж, хууль, эрх зүй болон шүүхийн шинэчлэлийг хийх, банкуудын чанаргүй зээлтэй ажиллах ажиллагааг үр дүнтэй болгон сайжруулах агуулгаар хэрэгжих юм.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Стратегийн хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг оруулах, шүүхийн бус замаар зээл олгогч байгууллагын санхүү, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх чиглэлээр харилцан уулзалтууд хийж, нэгдсэн систем, аргачлалыг удирдах байгууллагатай болох зэрэг ажил хийгдэх бөгөөд банкны системийн чанаргүй зээлийн хувийг 2021 он гэхэд 4-5, 2023 он гэхэд 2-3 хувь хүртэл бууруулах тоон зорилттой хэрэгжинэ.</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-32 дугаар тушаалаар “Чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам”-г батлан мөрдүүлж байна. Энэхүү журмыг хэрэгжүүлснээр барьцаа хөрөнгийг үүргийн гүйцэтгэлээр хангуулах эрх зүйн орчинг сайжруулж, чанаргүй активын хэмжээг бууруулсны дүнд банк суларсан эх үүсвэрээр зээл олгох, мөн чанаргүй активаас үүссэн алдагдал багассанаар банкны зээл хүү буурах үр нөлөөтэй.</li> <li>• Уг журмын хэрэгжилтийн хүрээнд банкуудын ТУЗ-р батлагдсан “Чанаргүй зээлийг бууруулах стратеги”-ийг 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч, цаашид хэрэгжилтийг хянаж ажиллахаар байна.</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А-302 дугаар тушаалаар “Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журам”,</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-308 дугаар тушаалаар “Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам”,</li> <li>• Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А-312 дугаар тушаалаар “Банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журам”-ыг тус тус баталсан. Банкинд албадлагын арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлснээр банкны салбар дахь шударга өрсөлдөөнийг дэмжих ач холбогдолтой.</li> <li>• Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Хяналт шалгалтын газраас 2018 онд нийт 14 банкинд газар дээрх иж бүрэн шалгалтыг хийж, мөн газар дээрх хэсэгчилсэн шалгалтуудыг хийж гүйцэтгэсэн болно.</li> </ul>				
	5-р зорилтын хүрээнд:	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 299 дугаар тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд “МУ-ын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх бодлого баримтлахаар тусгасан. Энэ зорилтын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.</p>				
14.	<b>Бүх шатны төрийн байгууллагад хамаарах</b>					
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийнүнэлгээ)	Биелэлт дундаж 94 %	Зорилтын тоо 5	Зорилт 1 100%	Зорилт 2 100%	Зорилт 3	

						90%
						Хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, батлуулах хүртэл хэрэгжинэ.
		Биелэлт дундаж	Зорилтын тоо	<b>Зорилт4</b>	<b>Зорилт5</b>	
15.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	94 %	5	100%	80%	Энэ хөтөлбөр нь 2025 он хүртэл хэрэгжинэ.

## Дүгнэлт :

### Зорилт №1.

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар арын 30-ны өдрийн А-193/228 дугаар хамтарсан тушаалаар “Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн ил тод байдлын журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 8 дугаар сарын 01 –ний өдрийн А-209 тоот тушаалаар “зээлийн мэдээллийн лавлагаанд тусах мэдээлэл”-ийн шалгуур үзүүлэлтийг тус тус баталж, холбогдох арга хэмжээг авсан. Энэ нь иргэдийн санхүүгийн зуучлалын үйлчилгээ авах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх арга хэмжээ болсон билээ.

### Зорилт №2

Банкны тухай хуулийн 10.1 дэх заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 хэсэгт “Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална” гэж зохицуулсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн ил тод байдлын журам”-ын 1.3.7, 1.3.8, 2.6, 2.7, 2.8 дахь заалтуудад өөрчлөлт оруулж, банкны хүү бодох аргачлалыг тухай бүр зээлдэгчид танилцуулж, бүрэн ойлголт өгөх эрх зүйн зохицуулалтыг тус тус тусгасан нь зээл авагчийн тэгш байдлыг бүрдүүлэхэд ач холбогдолтой өөрчлөлт болсон.

### Зорилт №3

Төв банк/Монголбанк/-ны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэсэн шинэ зохицуулалт орсны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар "Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан ба тус ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн,

хэрэглэгчийн төлөө газраас хамтран оролцож хуулийн төслийг боловсруулсан бөгөөд УИХ-ын хаврын чуулганаар өргөн барихад бэлэн болсон. Мөн Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын сайн засаглалыг бүрдүүлэх, төрийн зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох ажлыг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгээр хийж гүйцэтгэхээр тохиролцож байна.

#### **Зорилт №4**

Банкны тухай хуулийн 7 зүйлийн 7.4.1 дэх заалтад “дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох”-ыг хориглоно гэж заасан байна. Энэ заалтын дагуу Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 140/400/А-168/38 дугаар хамтарсан тушаалаар баталлаа.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-32 дугаар тушаалаар “Чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам”-г батлан мөрдүүлж байна.

Ингэснээр Банкны зах зээлд өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг шат дараатайгаар авч байна.

#### **Зорилт №5**

“МУ-ын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний банкны салбарын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх бодлого баримтлахаар тусгасан. Энэ зорилтын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцаат хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.